

КРИМИНАЛИСТИКИЙН БЭХЖҮҮЛЭХ ГЭРЭЛ ЗУРГИЙН ОНОЛ, ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

FORENSIC PHOTOGRAPHY THEORY AND SOME LEGAL PROBLEMS



Б.Хонгор

*Дотоод хэргийн их сургууль,
Шинжлэн магадлахуйн институт,
Шинжлэн магадлахуйн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч*

Товч утга: Криминалистикийн бэхжүүлэх гэрэл зургийн онол, эрх зүй зарим асуудлыг хөндөж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заагдсан ажиллагаа нь өнөөгийн бэхжүүлэх гэрэл зургийн арга, арга барил, төрөлтэй тохирч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Түлхүүр үгс: Криминалистик, гэрэл зураг, бэхжүүлэх гэрэл зураг, арга, арга зүй, арга барил.

Abstract: The theory and jurisprudence of forensic enhancement photography aims to determine whether the procedure prescribed in the Criminal Procedure Law is compatible with the current methods, methods and types of enhancement photography.

Keywords: Forensics, photography, strengthening photography, methods, techniques.

Шүүхийн шинжилгээний байгууллагад ажиллаж буй шинжээч мэргэжилтний үндсэн үйл ажиллагааны нэг бол гэмт хэргийн дуудлагад явж хэргийн газрын үзлэг хийж ул мөр, эд мөрийн баримт илрүүлэх, бэхжүүлэх, битүүмжлэх, орчны байдлыг гэрэл зургаар бэхжүүлэх, дүрс бичлэг хийх үүрэгтэй юм. Дээрх үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд Монгол улсад одоогийн байдлаар тогтсон стандарт байхгүй байгаа юм. Жишээлбэл зургийн хэмжээг хэд хэдийн харьцаатай хэвлэх, тэмдэглэгээ, тайлбарыг хэрхэн бичих, тэмдгийг хаана нь дарах, хэдэн удаа дарах, ямар нягтралтай хэвлэх, ямар хэвлэх төхөөрөмж ашиглаж хэвлэх, ямар зургийн цаасанд хэвлэх, хэвлэмэл хуудасны үсгийн хэмжээг зэрэг нь ямар ч стандартад орсон зүйл байхгүй байгаа нь шинжээч, мэргэжилтний эрх зүйн байдалд эрсдэлтэй байгаа юм. Тиймээс шинжээч өөрийн ажилласан хэргийн газар, мөрдөн шалгах ажиллагааны үеийн гэрэл зургийн үзүүлэлтийг батлагдсан стандарт, арга зүйн дагуу хийх нь нэн тэргүүний асуудал тул дээрх

сэдвийг сонгосон үндэслэл болов. Гэрэл зургийг анх 1839 онд Францын эрдэмтэн Ж.Ньепс, Л.Ж.Дагер нар нээж байжээ. Германы эрдэмтэн Э.Стенгер гэрэл зураг анх бий болсон өдрөөс эхлэн хэрэг шүүх ажиллагаанд ашиглагдаж эхэлсэн гэж нотолдог. Орост 1867 онд, Англид 1870 онд гэмт хэрэгтнүүдийн гэрэл зургийн цуглуулгатай болсон байна. 1859 оноос гэрэл зургийг хэргийн газрын үзлэгт ашиглаж эхэлсэн бол Монгол улсад 1928 оноос гэрэл зургийг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглаж эхэлсэн байна.

Криминалистик нь гэмт хэргийн бүтцийн зүй тогтол, гэмт хэрэг ба түүнд оролцогчдын тухай мэдээлэл бий болох зүй тогтол түүнчлэн нотлох баримт цуглуулах, шинжлэх, үнэлэх, ашиглах зүй тогтлууд тэдгээрийн танин мэдэхүйн дор суурилсан гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэрэгслийн тухай шинжлэх ухаан мөн хэмээн тодорхойлжээ¹⁶².

Монголын криминалистикийн байгууллагын хөгжлийн цаг хугацааны үе шатыг ажиглахад:

1928 онд Гэрэл зургийн лаборатори;

1944 онд УЦСГ-ын гүйцэтгэх хэлтэст шинжлэн магадлах техникийн IY тасаг;

1949 онд УЦСГ-ын Онцгой хэлтсийн гарын хээ судлалын тасаг;

1950 онд ДЯЯ-ны Онцгой хэлтсийн дэргэдэх Төвлөрсөн дактилоскопийн тасаг;

1956 онд УЦСГ-ын Шинжлэх ухаан техникийн тусгай тасаг;

1962 онд УЦСЕГ-ын криминалистикийн хэлтэс /ШУТ хэлтэс/;

1988 онд УЦСЕГ-ын криминалистикийн шинжилгээний төв;

Одоо үед Монголын криминалистикийн байгууллага нь гэмт хэргийг мөрдөн байцаах практикт криминалистикийн арга хэрэгслийг нэвтрүүлэхэд ихээхэн роль гүйцэтгэж яруу алдарт замыг туулж байна¹⁶³.

Криминалистикийн гэрэл зураг гэдэг нь гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэмт хэрэгтнийг эрэн сурвалжлах, илчлэх зорилгоор нотлох баримт цуглуулах, шинжлэх үед ашиглах гэрэл зургийн хэрэгсэл, арга, арга барил, түүний үндэс болсон шинжлэх ухааны мөрдлөг боловсруулах криминалистикийн техникийн хэсэг юм¹⁶⁴.

Гэрэл зураг үүсэж хөгжиж гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг илрүүлэх, нотлох ажиллагааны нэг үндсэн шалгуур болж байгаа юм. Техник технологи хөгжиж буйтай холбоотой шүүх гэрэл зургийн арга зүйг боловсронгуй болгох шаардлага нийгмээ дагаад тулгарч байгаа юм. Тиймээс дараагийн дэд бүлэгт бэхжүүлэх гэрэл

¹⁶² Ж.Хурцгэрэл – Криминалистик 1. УБ. 2002.

¹⁶³ С.Бадарчи - Хууль хамгаалах байгууллагуудын практикт криминалистикийн арга хэрэгслэл нэвтэрсэн нь. 2017. УБ.

¹⁶⁴ Ж.Хурцгэрэл – Криминалистик 1. УБ. 2002 он.

зургийн эрх зүйн асуудлыг хөндөхөөр болсон.

Криминалистикийн гэрэл зургийн тухай ойлголт

Криминалистикийн гэрэл зураг гэдэг нь гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэмт хэрэгтнийг эрэн сурвалжлах, илчлэх зорилгоор нотлох баримт цуглуулах, шинжлэх үед ашиглах гэрэл зургийн хэрэгсэл, арга, арга барил, түүний үндэс болсон шинжлэх ухааны мөрдлөг боловсруулах криминалистикийн техникийн хэсэг юм¹⁶⁵.

Гэрэл зургийн **объект** нь гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх үед зайлшгүй зургийг нь авах шаардлагатай болсон аливаа материаллаг юмс, тэдгээрийн хэсэг, эсвэл нийлбэр цогц байна. Жишээлбэл: Хэргийн газрын орчин, түүний хэсэг, мөр, биет баримт, хүн байж болно.

Гэрэл зургийн хэрэгсэл нь гэрэл зураг авах, хэвлэх төхөөрөмж болох фотоаппарат, дагалдах хэрэгсэл, лабораторийн төхөөрөмж, гэрэл зургийн хэрэглэгдэхүүн фотохальс, ялтас, фотоцаас, химийн уусмал.

Криминалистикийн гэрэл зургийн субъект, чиглэл:

- Эрэн сурвалжлах гэрэл зураг;
- Шүүх-хэрэг бүртгэлт - мөрдөн байцаалтын гэрэл зураг;
- Криминалистикийн шинжилгээний гэрэл зураг;

Криминалистикийн гэрэл зургийн зорилго:

- Бэхжүүлэх гэрэл зураг;
- Шинжлэх гэрэл зураг;

Бэхжүүлэх гэрэл зураг:

- Байцаан шийтгэх ба эрэн сурвалжлах ажиллагааны явц, үр дүнг гэрэл зургаар бэхжүүлэхийн тулд ашиглах арга, арга барил, хэрэгсэл, түүний үндэс болсон шинжлэх ухааны мөрдлөгийн тогтолцоо.
- Бэхжүүлэх гэрэл зургаар хүний нүдэнд ил тодорхой харагдах объектыг дүрсэлдэг.

Бэхжүүлэх гэрэл зургийн арга:

- Дэлгэмэл гэрэл зураг. /тойргийн, шугаман/
- Хэмжихүйн гэрэл зураг. /шугаман, гүний, квадрат дүрст/
- Стерео гэрэл зураг. /эзлэхүүнтэй, гурван хэмжээст дүрст/
- Хуулбарлах гэрэл зураг. /төхөөрөмж ашиглах, фото цаас ашиглах/
- Макро гэрэл зураг. /өсгөлттэй, цагаригийн тусламжтай/
- Таних гэрэл зураг. /хүн, цогцос, эд зүйл/
- Микро гэрэл зураг. /бянт, цохигчийн мөр/

¹⁶⁵ Ж.Хурцгэрэл – Криминалистик 1. УБ. 2002 он.

Бэхжүүлэх гэрэл зургийн төрөл:

- Хэргийн газрын.
- Нэгжлэгийн үеийн.
- Туршилтын үеийн.
- Гэмт хэрэгтний.
- Цогцосны.
- Бичиг баримтын.
- Мөр биет баримтын.

Доктор (Ph.D.), профессор Б.Бат-Эрдэнэ багшийн криминалистик (лекцүүд) 2017 оны номдоо дээрх байдлаар томъёолж, бүлэглэж бичсэн байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.3 дугаар зүйлд шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааны явцад, эсхүл шүүх хуралдаанд ул мөр, эд мөрийн баримт илрүүлэх, бэхжүүлэх, хамгаалах, техник хэрэгсэл, төхөөрөмж ашиглах, ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, хүний амь нас, эрүүл мэндэд аюул, эсхүл орчинд хөнөөл учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх, химийн хортой бодис, бусад эд зүйл байвал тэдгээрийг аюулгүй болгох, зөвлөгөө авах зорилгоор тухайн хэрэгт хувийн сонирхолгүй тусгай мэдлэг, туршлага бүхий хүнийг шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрээр мэргэжилтнээр оролцуулж болно гэж заасан байдаг тул шүүх шинжилгээний байгууллагын алба хаагч мөрдөн шалгах ажиллагаанд оролцож ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлж, битүүмжилж, мөрдөгчид хүлээлгэн өгч ажилладаг.

Тэгвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд дараах байдлаар мөрдөн шалгах ажиллагааг төрөлжүүлсэн байдаг байна.

ЭХХШТХ-ийн 23 дугаар бүлэг. Үзлэг, мөрдөн шалгах туршилт.

- 23.1 дүгээр зүйл. Үзлэг хийх;
- 23.2 дугаар зүйл. Хүний биед үзлэг хийх;
- 23.3 дугаар зүйл. Хэргийн газрын үзлэг;
- 23.4 дүгээр зүйл. Цогцост үзлэг хийх;
- 23.5 дугаар зүйл. Мөрдөн шалгах туршилт хийх;

ЭХХШТХ-ийн 24 дүгээр бүлэг. Нэгжлэг хийх, хураан авах.

- 24.1 дүгээр зүйл. Нэгжлэг хийх;
- 24.2 дугаар зүйл. Хүний биед нэгжлэг хийх;
- 24.3 дугаар зүйл. Орон байр, бусад газарт нэгжлэг хийх;
- 24.4 дүгээр зүйл. Эд мөрийн баримт хураан авах;

ЭХХШТХ-ийн 25 дугаар бүлэг. Мэдүүлэг авах, нүүрэлдүүлж мэдүүлэг авах, мэдүүлгийг шалгах, таньж олуулах.

- 25.6 дугаар зүйл. Мэдүүлгийг газар дээр нь шалгах;
- 25.7 дугаар зүйл. Таньж олуулах;

Криминалистикийн бэхжүүлэх гэрэл зураг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг арга зүй учир дээрх хуультай төрөл, агуулгатай таарч байх шаардлагатай юм.

Өнөөгийн криминалистикийн бэхжүүлэх гэрэл зургийн арга, арга зүй, төрөл нь стандартчилагдаагүй, хууль, эрх зүйгээр зохицуулагдаагүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай таарахгүй байгаа нь шинжилгээний байгууллагын алба хаагчдын эрх зүйн байдалд эрсдэлтэй байгаа юм.

Мөн гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хэргийн газрын, мөрдөн шалгах ажиллагааны гэрэл зургийг хэн ч харсан ойлгомжтой байдлаар хийх, зургийн хэмжээг олон улсын стандартын дагуу тогтоож стандартчилах, тайлбар, тэмдэглэгээг зөв оновчтой хийх нь хэргийг илрүүлэх болон шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм. Тиймээс криминалистикийн бэхжүүлэх гэрэл зургийн үзүүлэлт үйлдэх арга зүйг боловсронгуй болгох стандартчилах нь нийгмээ дагаад зайлшгүй хэрэгцээтэй зүйл болж байгаа юм. Мөн “Шүүх шинжилгээ-эрх зүй” мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнууд суралцах хугацаандаа хэргийн газрын үзлэгийн гэрэл зураг, мөрдөн шалгах ажиллагааны гэрэл зургийг хэрхэн авах, гэрэл зургийн үзүүлэлтийг хэрхэн үйлдэх ойлголт бага байдаг тул тэдэнд гарын авлага болгох мөн хэргийн газрын үзлэгийн гэрэл зургийн үзүүлэлт үйлдэх арга зүйг боловсронгуй болгоогүй орон нутгийн Шүүхийн шинжилгээний алба тус бүр өөрсдийн хэвшсэн гэрэл зургийн үзүүлэлт үйлдэх арга зүйтэй байгаа тул бэхжүүлэх гэрэл зургийн төрлийг дараах байдлаар ангилах нь зүйтэй гэж үзэж байна. Иймд доорх ангиллын дагуу цааш нь судалж, стандартчилах шаардлагатай байна.

Бэхжүүлэх гэрэл зургийн төрөл

1. Үзлэг, туршилтын

- 1.1. Хүний биед үзлэг хийх;
- 1.2. Хэргийн газрын үзлэг;
- 1.3. Цогцост үзлэг хийх;
- 1.4. Мөрдөн шалгах туршилт хийх;
- 1.5. Эд зүйлд үзлэг хийх;
- 1.6. Баримт бичигт үзлэг хийх;
- 1.7. Тээврийн хэрэгсэлд үзлэг хийх;
- 1.8. Ачаа тээшинд үзлэг хийх;
- 1.9. Мал, амьтанд үзлэг хийх;

2. Нэгжлэг хийх, хураан авах

- 2.1. Хүний биед нэгжлэг хийх;
- 2.2. Орон байр, бусад газарт нэгжлэг хийх;
- 2.3. Эд мөрийн баримт хураан авах;

3. Мэдүүлгийг шалгах, таньж олуулах

3.1. Мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагааны;

3.2. Таньж олуулах ажиллагааны;

Бэхжүүлэх гэрэл зургийн арга барил

- Баримжаалах. /астрофото, аэрофото, кримфото/
- Тоймлох.
- Зангилаа.
- Нэг бүрчилсэн. /макро/
- Нарийвчилсан. /микро/

Бэхжүүлэх гэрэл зургийн нарийвчилсан арга барил нь мөр, биет баримтын онцлог хэсэг, шинж тэмдгийг судлах зорилгоор томруулж, эсвэл өндөр өсгөлттэйгөөр дүрсэлсэн микро гэрэл зураг гэж тодорхойлсон байдаг бөгөөд дээрх тодорхойлолтод байх “микро” гэх нэр томьёо нь өнөөгийн бэхжүүлэх гэрэл зургийн арга, төрөл, арга барилд багтаагүй нэр томьёо байх тул “Бэхжүүлэх гэрэл зургийн арга”-д шинээр оруулах шаардлагатай байна.

Дүгнэлт

Судалгааны ажлын зорилго, зорилтын хүрээнд бэхжүүлэх гэрэл зургийн онол, эрх зүйн талаар нэгдсэн ойлголттой болов. Гэрэл зураг үүсэж хөгжиж эхэлсэн үеэс эхэлж түүнийг гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд ашиглаж ирсэн байдаг байна. даяаршиж буй нийгэмд нийгмийн хөгжлөө дагаад шинэ төрлийн гэмт хэрэг гарч байгаа нь криминалистикийн гэрэл зургийн онолын үндэс арга зүйг боловсронгуй болгох асуудал тулагч байгаа юм.

Шинжилгээний байгууллагын шинжээч шинжилгээ хийхдээ тогтсон стандарт арга зүй байхгүй, гэрэл зургийн үзүүлэлт үйлдэх тодорхойгүй нь түүний ажлын хүндрэлтэй мөн эрсдэлтэй болгож байгаа юм.

Шинжилгээний байгууллагын мөрдөн шалгах ажиллагааны үеийн тодорхой төрлийн гэрэл зургийн үзүүлэлтэд судалгаа хийж үзэхэд зургийн төрөл, арга, арга зүй, тодрол, хэмжээ, дэс дараалал, тэмдэг тэмдэглэгээ, талбайн ашиглалт, зургийн тоо дутсан, стандарт байхгүй, албан хэрэг хөдлөлтийн стандартын дагуу хийгдээгүй зэрэг алдаатай зүйлүүд байв. Тиймээс энэ алдааг гаргахгүй болон шинжээчийн эрх зүйн байдлыг баталгаатай болгохын тулд бэхжүүлэх гэрэл зургийн арга, арга зүй, төрлийг стандартад оруулах нь зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

- С.Бадарчи – Хууль хамгаалах байгууллагуудын практикт криминалистикийн арга хэрэгсэл нэвтэрсэн нь. 2017. УБ.
- Ж.Хурцгэрэл – Криминалистик 1. УБ. 2002.
- Б.Бат-Эрдэнэ – Криминалистик. УБ. 2017.
- Б.Жаргалсайхан – Учралын газрын үзлэг. УБ. 2018.

- Т.Очирбат – Диссертаци. УБ. 2019.
 - Б.Лхагвасүрэн – Мөр. УБ. 2015.
 - Я.Цэвэл – Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1996.
 - Т.В.Аверанова, Р.С.Белкин, Ю.Г.Корухов, Е.Р.Россинская –
Криминалистик. 2002.
 - Г.Мөнхбат, М.Энхбаяр, Г.Дагиймаа – Хагас зууны хөгжлийн түүх. 2010.
- ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АКТ:
- Эрүүгийн хууль
 - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
 - Шүүх Шинжилгээний тухай хууль

---o0o---